



ДУНДГОВЬ АЙМАГ
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 01 өдөр

Дугаар А/2029

Мандалговь

Зохион байгуулалтын арга хэмжээ
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", "ж", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх хэсэг, аймгийн засаг даргын 2020 оны А/352 дугаар захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчлэн шилжүүлсэнтэй холбогдуулан шинэ коронавирус (Ковид-19)-ийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор сумын хэмжээнд соёл, урлаг, спорт болон олон нийтийг хамарсан бүх төрлийн үйл ажиллагааг 2020 оны 12 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 11 -ны өдрийг дуустал хугацаанд түр хориглосугай.

Хоёр. Нийслэл хотоос тус суманд ирэх иргэдийг гэрийн тусгаарлалтанд оруулах, хянах журмыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

Гурав. Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан сумын онцгой комиссын жижүүрийг 2 дугаар, гэрийн ажиглалтанд байх иргэдэд хяналт тавих албан хаагчдын нэрийг 3 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

Дөрөв. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг сумын засаг даргын орлогч /О.Баярсайхан /, ЗДТГазрын дарга /Б.Оюунчимэг / нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Р.МӨНХТОГТОХ